



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 04 сарын 02 өдөр

Дугаар А/157.

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Номын сангийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” 03/02 дугаар тогтоолоор батлагдсан аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1.1.1.9, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэдэд хүргэх номын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Аймгийн Төв номын санд фондод баяжилт хийхэд 5,000,000 (таван сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Уншигчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн номоор фондбаяжилт хийж, номын ашиглалтад хяналт тавьж ажиллахыг аймгийн Төв номын сан (Л.Анхбаяр)-д үүрэг болгосугай.

3.Дээрх зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100338